



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2018 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 273

Улаанбаатар хот

Төрийн болон орон нутгийн өмчийн
эд хөрөнгийн бүртгэлийн талаар авах зарим
арга хэмжээний тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.2.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн бүртгэлийг сайжруулах зорилгоор ТОГТООХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгийн анги доторх зүйлийг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн зөв ангилан бүртгэх, буруу бүртгэснийг данс хооронд шилжүүлэх замаар запруулан бүртгэхийг дарга, захирал нарт зөвшөөрсүгэй.

2. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Газраас салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд хөрөнгийг “барилга байгууламж” дансанд ангилан (шилжүүлэн) бүртгэх, “барилга, байгууламж” дансанд бүртгэлтэй боловч дээрх шинжийг агуулаагүй, хөдлөх эд хөрөнгийг бусад холбогдох дансанд шилжүүлэн бүртгэх асуудлыг 2018 оны 8 дугаар сард багтаан шийдвэрлэх;

2.2. Хөрөнгийн нэр, нэршлийг монгол хэлээр, оновчтой бүртгэх, запруулах, хэмжих нэгж, тоо хэмжээг холбогдох стандарт, аргачлалын дагуу тодорхойлж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А/19 дүгээр тушаалаар батлагдсан төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн маягтад заасан эд хөрөнгийн ангиллын кодыг хөтөлж хэвшүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д оруулах ажлыг зохион байгуулах;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

